



ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЛИЙН АУДИТ



АУДИТЫН ЗОРИЛГО:

Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх, үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байгаа эсэх

ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГА:




Аймгийн CTCX
17 сумын Төрийн сан
182 төсвийн байгууллага
1022 данс
2023-2025 он




42 төрийн сангийн албан хаагч
462 системийн хэрэглэгч
298,962 гүйлгээ

Орон тооны бүтэц



1 өдрийн дундаж хянасан гүйлгээний тоо



Цахим системийн давуу тал

- Зайнаас ажиллах боломжтой
- Аюулгүй ажиллагаа хангагдсан

Сул тал

- Интернет голдог
- Ачаалалтай үед зарим гүйлгээний нотлох баримт харагддаггүй



Төрийн сангийн албан хаагчидыг тогтвор суурьшилтай ажиллуулах хэрэгцээ, шаардлага байна



Төрийн санг анх байгуулахдаа хүн амын тоо, байгууллагын тоог харгалзахгүйгээр байгуулснаар ажлын ачаалал харилцан адилгүй байна



Цахим систем, төрийн сангийн албан хаагчдын тоног төхөөрөмжийг сайжруулах шаардлагатай байна



АУДИТААР НИЙТ 1,144.8 САЯ ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛ ИЛЭРЛЭЭ.



ТӨЛБӨРИЙН АКТ-3 276.1 сая төгрөг



Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Чандмань сумын тохижилтын цэцэрлэгт хүрээлэнгийн ажлыг хийгээгүй, нэмэлтээр ЗДТГ-ын хуучин байрны дотор тохижилтын ажилд зарцуулсан ч төсөвт өртөг нь 10.6 сая төгрөгөөр дутуу, авто зогсоол барих ажлыг тоо хэмжээнээс дутуу хийсэн



Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Чандмань сумын тохижилтын хашаа барих ажлыг ажлын тоо хэмжээнээс дутуу хийсэн, хагяжуулах ажлыг хийгээгүй



Ангийн орлогын тооцоо бодоогүй, орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн



ЗӨВЛӨМЖ-6 640.5 сая төгрөг



Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг доор дэлгэрэнгүй оруулсан.



АЛБАН ШААРДЛАГА-2 228.1 сая төгрөг



Байр ашиглалтын тогтмол зардлын ангиллаас эдийн засгийн агуулга өөр буюу Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан журмын 2103 ангилалд хамааралгүй зардлыг санхүүжүүлсэн



Ангийн дуудлага худалдааг хаалттай хэлбэрээр зохион байгуулахдаа ан агнах зөвшөөрөлтэй эрх бүхий аж ахуйн нэгжүүдийг оролцуулаагүй



Хуулийн байгууллагад 1 асуудлыг шалгуулах



Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Чандмань сумын тохижилтын хашаа барих ажлыг ажлын тоо хэмжээнээс дутуу хийсэн, хагяжуулах ажлыг хийгээгүй тул хуулийн байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн

ДҮГНЭЛТ



1 Сангийн сайдын журамд сумдын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн нар нь ээлжийн амралттай үед эрхээ хэрхэн шилжүүлэх нь тодорхой бус байгаагаас гүйлгээ хянах батлах эрхийг хоорондоо шилжүүлж байгаа нь зарлагын гүйлгээний хяналтыг сулруулах эрсдэлтэй байна



2 Санхүүгийн алба нь сумын ЗДТГ-т харьяалагдаж байгаа нь хяналтыг хараат бусаар, үр нөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг бууруулж байна



3 Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн нарын албан тушаалын тодорхойлолтод ажилласан жил зааж өгөөгүйгээс ажлын туршлагагүй, төрийн сангийн цахим системийн талаар мэдлэггүй албан хаагчид томилогдох эрсдэл бий болжээ



4 Төрийн сан нь зарлагын гүйлгээний хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс хууль, журмаар хориглосон, анхан шатны иж бүрэн бус баримттай ажил гүйлгээг санхүүжүүлдэг зөрчил буурахгүй байна



5 Санхүү төрийн сангийн хэлтэс нь дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс хяналтаар өгөгдсөн зөвлөмжүүд хэрэгжихгүй, зөрчил давтан гарсаар байна



6 Сумдын ОНХС хариуцсан нягтлан бодогчид Сангийн сайдын 2023 оны 444 дүгээр тогтоолын хавсралт маягтыг мөрдөөгүйгээс хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн санхүүжилтийг батлагдсан маягтын дагуу гаргаагүй



7 Ангийн дуудлага худалдааны орлогод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс ялагч нь хуульд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй байхад нэгжийг ялгагчаар баталгаажуулжээ



ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС



Төрийн сангийн дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, эрсдэл өндөртэй сумдад хуваарь гарган баталж, хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллах



Сумдын санхүүгийн албаны албан хаагчдыг мэдээлэл, арга зүйгээр тогтмол ханган, дотоод сургалтыг үр дүнтэй зохион байгуулж албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх



Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулах эрхийг нээхдээ холбогдох баримт бичгийг иж бүрэн хүлээн авч архивын нэгж үүсгэж ажиллах



Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс нь цахим болон цаасан хэлбэрээр үүсгэсэн баримтуудыг аймгийн ЗДТГ-ын архивд хүлээлгэн өгч ажиллах

Ангийн дуудлага худалдааны орлогод тавих CTCX-ийн орлогын мэргэжилтний хяналтыг сайжруулан ажиллах



Төсвийн гүйцэтгэлийн тайлан мэдээг хууль журамд заасан хугацаанд иж бүрэн авч, орон нутгийн төсвийн байгууллагуудын өр төлбөр авлагад үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажиллах